



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

### Дугаар №17



2018 оны 5-р сарын 14-18-ны хооронд

#### НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй байж болзошгүй нийт **613** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 58(9.5%) галзуугийн эрсдэлд өртсөн, 547(89.2%) хачигт халдвар, 2(0.3%) бэтэг, 1(0.2%) хумхаа, 5(0.8%)-ийг боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

##### 1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 101 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 547 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 21.2%-иар, эпидемиологийн 19-р долоо хоногтой харьцуулахад 23%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



5 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар хачигт риккетсиоз 25(4.6%), хачигт боррелиозын 8(1.5%) тохиолдол тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдаж, 45 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

##### 1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 25 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 58 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 37.6%-иар буурсан. Эпидемиологийн 19-р долоо хоногт 1 тохиолдол бүртгэгдсэн.



### 1.3 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Ховд, Төв, Дорнод аймгийн 4 суманд боомын арьсны хэлбэрийн хүний өвчлөлийн сэжигтэй 5 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр тохиолдол үгүйсгэгдсэн байна.

### 1.4 Бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Увс аймгийн Улаангом сум, нийслэлийн ХУД-ээс бэтэг өвчний онош тодруулахаар 2 хүний шинжилгээний материал ЗӨСҮТ-ийн лабораторит хүлээн аваад байна.

### 1.5 Хумхаа өвчний сэжигтэй тохиолдол:

Канад улсын иргэн. Өвчтөн “D” 34 настай, эмэгтэй. 2018 оны 3 дугаар сарын 16-29-ний хооронд Индонез улсад зорчих үедээ шумууланд хазуулсан өгүүлэмжтэй. 3 дугаар сарын 31-ний өдөр толгой өвдөх, дотор муухайрах, бүх бие янгинах, гүйлгэх шинж тэмдэг илэрч, Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний өдөр хэвтсэн.

#### Хариу арга хэмжээ:

- Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний 14 цагийн орчимд ЗӨСҮТ-ийн дуудлагын баг газар дээр нь очиж ажилласан.
- Өвчтнийг тусгаарлаж, хумхаа өвчний онош тодруулахаар сорьц дээжилж, ЗӨСҮТ-ийн лабораторид нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн шинжилгээгээр цусанд хумхаа өвчний үүсгэгчийн ДНХ тодорхойлогдоогүй онош үгүйсгэгдсэн.

### 1.5 Мэрэгч амьтны дуудлага:

2018 оны гарсаар нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, \*ЧД)-ийн хэмжээнд нийт 18 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Тайлбар: \* 1 удаа

## ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

### Монгол улсад:

#### Мал, амьтны галзуу өвчин:

Баянхонгор аймгийн Баацагаан сумын 2-р багт 2018 оны 5 дугаар сарын 11-ны өдөр малчин айлын 1 ямаанд мал амьтны галзуу өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч Аймгийн ХХААГазрын төв лабораторийн шинжилгээгээр галзуу өвчнөөр өвчилсөн болох тогтоогдсон байна.

### Хариу арга хэмжээ:

Голомтот нутгийн 11 өрхийн 38 хүнд биеийн үзлэг хийж, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа хийсэн.

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗӨСТ

### Олон улсад:

#### Эбола вирус халдвар:

5 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вирус халдварын шинэ дэгдэлт бүртгэгдэж, 39 тохиолдол бүртгэгдэж, 19 хүн нас барсан. (Нас баралтын түвшин 49 хувь)-тай байна.



Figure 1: CARTE DES ZONES DE SANTE DE LA PROVINCE DE L'EQUATEUR

#### Авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ:

- ДЭМБ-аас дэгдэлтийн судалгаа хийхээр 50 гаруй мэргэжилтэн ажиллаж байна.



- Тус улсын нөхцөл байдалтай ДЭМБ-ын Ерөнхий захирал газар дээр нь очиж ажиллан, гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас 2.6 сая ам долларын санхүүжилтийг өгөхөөр шийдвэрлэжээ.
- ДЭМБ тус улсын Засгийн газар Медецинс Санс Пронтейрэс, Дэлхийн Хүнсний Хөтөлбөр, Олон Улсын Улаан Загалмайн Холбоо, Нэгдсэн Үндэстний байгууллага, АНУ-ын Өвчний Хяналт Сэргийлэлтийн Төв байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- ДЭМБ-аас тус улсын аялал жуулчлал болон улс орны хилээр нэвтрэх олон улсын хөдөлгөөнийг хязгаарлаагүй байна.

Эх сурвалж: ДЭМБ

#### Шувууны томуу өвчин:

Өмнөд Африк улсын Баруун Кейп мужийн Oudtshoorn гэдэг газрын шувууны аж ахуйд, шувууны томуугийн H5N8 вирус халдварын дэгдэлт бүртгэгдэж, 3730 шувуу өртөмхий байснаас, 29 шувуу өвчилсөн байна. Голомтот хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.



Эх сурвалж: ДЭМБ

### **Мал, амьтны галзуу өвчин:**

Малайз улсын Сарабак хотын Кучин мужид мал, амьтны галзуу өвчний улмаас, 1 нохойг устгаж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Тус хотын 8088 муур, 54492 нохойд вакцинжуулалт хийгджээ.



Эх сурвалж:ДАЭМБ

### **Туулайн вируст цусан халдвар өвчин:**

Шинэ Зеланд улсын Марлборо мужийн Аватере хөндийн аж ахуйд, туулайн вируст цусан халдвар өвчний улмаас, 1 туулай өвчилж үхсэн байна. Тус бүсэд хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

Эх сурвалж:ДАЭМБ

### **Рифт хөндийн чичрэг өвчин:**

Өмнөд Африк улсын Фрэй Стате мужийн хонины аж ахуйд, Рифт хөндийн чичрэг өвчний улмаас, 600 хонь өртөмхий байснаас, 250 хонь өвчилж үхсэн. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.



Эх сурвалж:ДАЭМБ